

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ
ХУРАЛДААНААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2022.03.28

Дугаар 25

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Биелэлт ирүүлэх хугацаа	Биелэлт
1	Алтанцөгц, Бугат, Өлгий сумдад мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин тархах бодит нөхцөл бололцоо бүрдүүлсэн, албан үүрэгтээ хариуцлагагүй хандсан зарим албан тушаалтнуудад хариуцлага тооцох хууль зүйн үндэслэлийг судалж, шийдвэрийн төслийг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулах	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн дарга Ө.Хуралай	III/31	Нэр бүхий албан тушаалтнуудад хариуцлага тооцох хууль зүйн үндэслэлийг судалж, шийдвэрийн төслийг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулсан болно.
2	-2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр 16:00 цагт аймгийн ХДТ-т зохион байгуулагдах “Эртэч Монгол” цугларалтад байгууллага болгон 10-аас доошгүй ажилтан оролцуулах - 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдөр 06:30 цагт аймгийн төв талбайд зохион байгуулагдах “Эртэч Монгол” нийтийн цугларалтад аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн бүх шатны байгууллагын албан хаагчдыг бүрэн оролцуулах арга хэмжээ авах	СУГ-ын дарга К.Бекжан БТСГ-ын дарга Х.Хайнар Нийт байгууллага, агентлаг	III/31	Бүх байгууллага, агентлагууд 03 дугаар сарын 28-ны өдөр 16:00 цагт аймгийн ХДТ-т зохион байгуулагдсан “Эртэч Монгол” цугларалтад 10-аас доошгүй ажилтан оролцуулж, 03 дугаар сарын 29-ний өдөр 06:30 цагт аймгийн төв талбайд зохион байгуулагдсан “Эртэч Монгол” нийтийн цугларалтад албан хаагчдаа бүрэн оролцуулсан гэх биелэлтийг ирүүлсэн.
3	“Эрүүл Монгол хүн” аяны хүрээнд төрийн байгууллагын албан хаагчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2022 оны 04 дүгээр сарын 15-наас 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд бүрэн хамрагдах	Нийт байгууллага, агентлагийн дарга нар	III/31	Байгууллагынхаа албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2022 оны 04 дүгээр сарын 07-ноос 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд бүрэн хамруулна гэх биелэлтийг бүх байгууллага, агентлагуудаас ирүүлсэн.
4	Гамшгаас хамгаалах команд штабын сургалтад бэлдэх, мэргэжлийн ангиудын бэлтгэл, бэлэн байдлыг хангах арга хэмжээ авах	Нийт байгууллага, агентлаг	III/31	Гамшгаас хамгаалах команд штабын сургалтад бэлдэх, мэргэжлийн ангиудын бэлтгэл ажил, бэлэн байдлыг хангах зорилгоор Бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Үүнд: 1. Мэргэжлийн ангийн хувцасны жигдрэлт, хээрийн үүргэвчийн бүрдэл бэлэн болсон. 2. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг шинэчилж

				байгуулсан. 3.Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинээр боловсруулж ОБГ-ын холбогдох албан тушаалтнуудад хянуулахаар хүргэсэн байна. 4. Тээврийн хэрэгсэл, багаж зэвсэгийн жагсаалтыг гаргаж бэлэн болгосон 5. Мэргэжлийн ангиудын бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах төлөвлөгөө гаргаж, алба хаагчдад жагсаалын бэлтгэл хийлгэн ажиллаж байна гэх биелэлтүүдийг нийт байгууллага, агентлагаас ирүүлсэн байна.
5	2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдах аймгийн ИТХ-ын ээлжит VII хуралдаанд холбогдох дэд хөтөлбөр болон журмын төслийг байгууллагын дарга нар өөрсдөө танилцуулах, бүрэн оролцох	Холбогдох байгууллага, агентлаг	III/31	Аймгийн ИТХ-ын ээлжит VII хуралдаанаар батлуулах дэд хөтөлбөр болон журмын төслийг байгууллагын дарга нар өөрсдөө танилцуулж, бүрэн оролцсон талаарх биелэлтийг ирүүлсэн.
6	Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний хорио цээр тогтоосон сумдад хяналт-шалгалтын ажлыг өндөр хэмжээнд зохион байгуулах	Аймгийн ОБГ-ын дарга З.Азат	III/31	Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний хорио цээр тогтоосон сумдад өдөр бүр хяналт тавьж, томилгоот албан хаагчид хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР